



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 04

Чойр

Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, “е”, 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 15 дугаар зүйлийн 15.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэгдүгээр хавсралтаар, Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий “Говьсүмбэр аймгийн 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт болон зээл, тусламжийн хөрөнгөд тусган хэрэгжүүлж, биелэлтийг тайлagnаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батзам/-д даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ж.Оюунбилэг/-т, Хороодын дарга нарт үүрэг болгосугай.


4. Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ш.БИЛЭГГҮМБЭРЭЛ

Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 08 дугаар
хуралдааны 04 дугаар тогтоолын 01 дугаар хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Зорилго 1. Үндэсний эх хэл, түүх соёл, Боржигин өв соёлоо дээдэлсэн аймаг болно.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Үндэсний бахархал, эв нэгдэл

Зорилт 1.1. Боржигин зан заншил, өв соёлыг хамгаалж, түгээн дэлгэрүүлнэ:

1.1.1. Боржигин түмний өв соёлыг сэргээсэн, ёс заншил, үйл ажиллагааг тусгасан, утга зохиол, уран бүтээлүүдийг туурвиход дэмжлэг үзүүлнэ.

1.1.2. Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үед өвлүүлэх, сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, хөдөөгийн багийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг үзүүлнэ.

1.1.3. Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулан, орчин нөхцөлийг сайжруулж, техник тоног төхөөрөмжөөр хангана.

Монгол хэл, бичиг

Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл

Зорилт 1.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшинэ:

1.2.1. Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид болон төрийн байгууллагуудын албан хаагчдын Монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлж, уламжлалт Монгол бичгийг албан хэргийн түвшинд ашиглаж эхэлнэ.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн орчныг бүрдүүлнэ.

**Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:
Боловсрол**

Зорилт 2.1. Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг тэгш хангана:

2.1.1. Яслид 1-2 насны хүүхдийг, сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхдийг хамруулан, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, сургуульд суралцах бэлтгэлийг хангана.

2.1.2. Цахим зайн сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа орон зайнлас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ.

2.1.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарын судалгааг жил бүр зохион байгуулан, үр дүнг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.1.4. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг үе шаттай хангана.

2.1.5. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэн, тусгай хэрэгцээт хүүхдийг өрдийн сургууль, цэцэрлэгт суралцах, хөгжихөд дэмжиж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна.

2.1.6. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгож, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлнэ.

2.1.7. Ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчийг “Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй болно.

2.1.8. Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.

2.1.9. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ.

Эрүүл мэнд

Зорилт 2.2. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг сайжруулж, чадавхыг дээшлүүлнэ:

2.2.1. Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулж, халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, иргэдийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, нас баралтын түвшинг бууруулна.

2.2.3. Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нутагшуулна.

2.2.4. Яаралтай тусlamж үйлчилгээний хүртээмж чадавхыг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.

2.2.5. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ.

2.2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.

2.2.8. Эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах бэлтгэл ажлыг бүрэн хийнэ.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Зорилт 2.3. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлого хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжинэ:

2.3.1. Хүүхдийн хөгжил авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.3.2. Хүүхэд, хамгааллын үйлчилгээг сайжруулж, хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамт шахалт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

2.3.3. Гэр бүлийн хөгжил, тогтвортой хөгжлийг дэмжих гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн харилцаа хандлагад нөлөөлнэ.

2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.

2.3.5. залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновац

Зорилт 2.4. Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт нэвтрүүлж хэрэгжүүлнэ:

2.4.1. Орон нутагт стандартчилал, хэмжил зүйн нэгж байгуулна.

2.4.2. Судалгаа, шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран орон нутгийн түвшинд судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж, инновацыг нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.

Хүнд ээлтэй амьдрах орчин

Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:

2.5.1. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.2. Эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээг хийж, орчны бохирдлыг үе шаттайгаар багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.

2.5.3. Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлцуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.5.4. Айл өрхийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.

Хөдөлмөрийн зах зээл

Зорилт 2.6. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана:

2.6.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулна.

2.6.2. Ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.6.3. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.

Монгол хүний удмын сан

Зорилт 2.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ:

2.7.1. Хүн бүр ураг удмаа мэдэж, өрх бүр угийн бичгээ хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ.

2.7.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын бүртгэл, хяналтыг сайжруулна.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлого, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Нийгмийн хамгаалал

Зорилт 3.1. Нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ:

3.1.1. Нийгмийн халамж, зорилтот бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээг ил, тод нээлттэй чирэгдэлгүй хүргэнэ.

3.1.2. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.

Орлогод нийцсэн орон байр

Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангана:

3.2.1. 540 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.2.2. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, бетон зуурмаг, вакум цонх, бетон эдлэл зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг бэхжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес

Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлт, ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ:

3.3.1. Залуучуудад бизнес эрхлэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоодын үйл ажиллагааг дэмжинэ.

3.3.3. Орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудын чадавхыг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Зорилт 3.4. Биеийн тамир, спортын үйл ажиллагаанычанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлнэ:

3.4.1. Нийтийн биеийн тамирыг дэмжиж эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, иргэдийн хамрагдах хувийг нэмэгдүүлнэ.

3.4.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.4.3. Орон нутгийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хувшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлж, мэргэжлийн спортыг дэмжиж ажиллана.

Газрын харилцаа

Зорилт 3.5. Аймгийн хэмжээнд газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ:

3.5.1. Хаягжилтынажлыгүргэлжлүүлэн, мэдээллийн санг хөтөлнө.

3.5.2. Газар ашиглалт, газрынмониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5.3. Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн үйл ажиллагааг сайжруулна.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

Зорилго 4. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бизнес эрхлэх орчныг сайжруулан, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжиж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Чинээлэг Монгол

Зорилт 4.1. Орон нутагт бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ:

4.1.1. Бизнес эрхлэгчдийг чадавхжуулж, инноваци, дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийгнэвтрүүлнэ.

4.1.2. Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

4.1.3. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Зорилт 4.2. Орон нутгийн тэргүүлэх салбарынхүнд, хөнгөн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ:

4.2.1. Хүнд үйлдвэрийн бүс байгуулж, боловсруулах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.

4.2.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, экспортыг дэмжинэ.

4.2.3. Хөдөө аж ахуйн болон эрчимжсэн мал аж ахуйн парк байгуулах ажлыг бодлогоор дэмжиж, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг түргэтгэнэ.

Ухаалаг санхүүгийн зах зээл

Зорилт 4.3. Эдийн засгийг тэтгэсэн, олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ:

4.3.1. Хууль, эрх зүйн орчны хүрээнд орон нутаг дахь даатгалын салбар, бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, тогтвортой байдлыг хангана.

4.3.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулна.

Бус нутгийн хамтын ажиллагаа

Зорилт 4.4. Хөрш орнуудтай эдийн засгийн коридороор гадаад худалдаа хийх, гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ:

4.4.1. Монгол Улс, Оросын холбооны улс, Бүгд найрамдах Хятад ард улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах форум, уулзалт, үзэсгэлэн худалдаанд төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг оролцуулна.

4.4.2. Зүүн хойд Азийн хотуудын холбоо (NEAR)-ны хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулах, БНСУ, Турк, Япон болон бусад гуравдагч улс, орнуудын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч, иргэдийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн

Зорилт 4.5. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ:

4.5.1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжинэ.

4.5.2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.5.3. Хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, эрх ашгийг хамгаалан дэмжинэ.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго 5. Хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо бүхий, авлигагүй, иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлж, төрийн албанад ухаалаг, цахим үйлчилгээг нэвтрүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үрдүн:

Ухаалаг засаглал

Зорилт 5.1. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, төрийн бодлого, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ:

5.1.1. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулж, албан хаагчдыг мэргэшүүлэн, төрийн үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай барилга, дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

Ухаалаг бүтэц

Зорилт 5.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, гадаад хамтын ажиллагаанд нэг цонхны нэгдмэл бодлогыг хэрэгжүүлнэ:

5.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж эхэлнэ.

5.2.2. Гадаадын хөрөнгө оруулагч аж ахуй нэгж, бизнес эрхлэгч иргэдийн харилцаанд нэг цонхны нэгдмэл бодлогыг баримтлан ажиллаж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Цахим Монгол (Иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)

Зорилт 5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим орчныг бүрдүүлэн, ил тод байдлыг ханган, иргэд, олон нийт мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг цахимаар авах орчин нөхцөлийг бүрдүүлнэ:

5.3.1. e-mongolia системээр төрийн үйлчилгээ авах орчин нөхцлийг бүрдүүлж, хөдөөгийн багуудадинтернэт сүлжээг нэвтрүүлнэ.

5.3.2. Төрийн үйлчилгээнд ХҮР, ДАН систем, тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд үйлчлэх үйлчилгээний нэгдсэн төвийг өргөжүүлнэ.

5.3.3. Төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангуулж, дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэн тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэнэ.

Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба

Зорилт 5.4. Төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, чадахуйн зарчимд сууриссан, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлж, үйл ажиллагаа, үр дүнг сайжруулна:

5.4.1. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлнэ.

5.4.2. Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

5.4.3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг ханган, тогтвортой ажиллах, төрийн албанда шатлан дэвших зарчмыг хэрэгжүүлнэ.

Хүний эрхийг дээдэлсэн нийгэм

Зорилт 5.5. Хүний эрхийг хангах талаар төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, олон нийтийн хүний эрхэд сууриссан хандлагыг төлөвшүүлнэ:

5.5.1. Олон нийтийн хүний эрхэд сууриссан хандлагыг төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

Авлигагүй засаглал

Зорилт 5.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн нийтийн хандлагыг төлөвшүүлнэ:

5.6.1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ

Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Эх байгаль анхдагч экосистем

Зорилт 6.1. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий нутгийг судалж, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлнэ:

6.1.1. Булаг шандны эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлэн, хөв цөөрөм байгуулна.

6.1.2. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

Байгалийн баялгийн үр өгөөж

Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээнэ:

6.2.1. Эвдрэлд орж, доройтсон газрыг нөхөн сэргээн, туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулна.

6.2.2. Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулж, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

6.2.3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

6.2.4. Ойн зурvas, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

6.2.5. Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ.

Үнэт баялаг ус

Зорилт 6.3. Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлэн, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, зохистой ашиглана:

6.3.1. Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, цэнгэг усны орд газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

6.3.2. Төв суурин газрын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.

6.3.3. Аймаг, сумдын төвийн ундны усны эх үүсвэрт нөөцийн судалгаа хийнэ.

Нүүрс төрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт 6.4. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологийг нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулна:

6.4.1. Ногоон эдийн засгийг дэмжих төсөл хөтөлбөрт орон нутгийн байгууллагуудыг хамруулна.

6.4.2. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлж, байгалийн гамшигийн эрсдэлийг бууруулна.

6.4.3. Ногоон худалдан авалтын худалдан авалтанд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

6.4.4. Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн, аймгийн төвд ландфилл технологийг сайжруулна.

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Зорилго 7. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшигийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Зэвсэгт хүчин

Зорилт 7.1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ:

7.1.1. Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ.

Хүн, нийгмийн амар тайван байдал

Зорилт 7.2. Гэмт хэрэг зөрчил, гамшгаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ:

7.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шинэ техник, технологийн дэвшилийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.

7.2.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

7.2.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулан, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

7.2.4. Орон нутгийн аюулгүй байдлыг хангах үүднээс бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий хүнсний агуулах барихыг дэмжинэ.

7.2.5. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулна.

7.2.6. Гэр булийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

Хууль сахиулах салбарын хөгжил

Зорилт 7.3. Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлнэ:

7.3.1. Аймаг, сумдын төвийн камержуулалтын системийг шинэчилж, өргөтгөнө.

7.3.2. Шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

7.3.3. Гэмт хэрэг зөрчлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

7.3.4. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй оролцогчийн эрхийг хангахад Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллана.

Мэдээллийн аюулгүй байдал

Зорилт 7.4. Кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавхыг дээшлүүлнэ.

7.4.1. Кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавхыг дээшлүүлнэ.

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго 8. Орон нутгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, аймаг, сумдын төвийн дэд бүтцийг сайжруулж, орон нутгийг хөгжүүлнэ.

Зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилт, хүрэх үр дүн:

Дэд бүтэц

Зорилт 8.1. Аймаг, сумдын төвийндэд бүтцийг сайжруулна:

8.1.1. Аймаг, сумдын төвд шинээр авто зам барьж, улсын чанартай автозамтай холбоно.

8.1.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто үйлчилгээний төв байгуулна.

8.1.3. Дэд бүтцэд тулгуурлан тээвэр, логистикийн төв байгуулна.

8.1.4. Хэрлэн голын Хөмөлтэйн гүүр, Чойр-Мандалговь чиглэлийн авто замын ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллана.

8.1.5. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

8.1.6. Аймгийн төвд дулааны станц байгуулна.

8.1.7. Аймаг, сумдын төвд цэвэрлэх байгууламж барина.

8.1.8. Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний өөрчлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ.

8.1.9. Сүмбэр сумын төвд дахин төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

8.1.10. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтыг сайжруулж, аймаг сумдын төвд дугуйн зам, явган хүний зам, гудамжны гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлнэ.

8.1.11. Шинээр өмчлөлд олгосон газруудад цахилгаан татаж, гэр хорооллын цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

8.1.12. Аймаг, сумдын шилэн кабель, цахилгаан холбоо, үүрэн телефоны сүлжээг өргөтгөнө.

Аялал жуулчлал

Зорилт 8.2. Орон нутгийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ:

8.2.1. Орон нутгийн онцлогийг шингээсэн түүхэн өв соёл, шашин, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулан, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

Тогтвортой хөдөө аж ахуй

Зорилт 8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ:

8.3.1. Мал аж ахуй, газар тариалангийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

8.3.2. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж тогтвортой байдлыг хангана.

8.3.3. Малын чанар, ашиг шимийг сайжруулан, тоог чанарт шилжүүлж, удмын санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн, эрчимжсэн мал аж ахуйг дэмжинэ.

8.3.4. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авч, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаална.

8.3.5. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр, борлуулалт хадгалалтын логистикийн сүлжээг бий болгож, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

8.3.6. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

8.3.7. Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, малын үүлдэр, угсааг сайжруулах, малын гаралтай түүхий эд үйлдвэрлэгчдийг дэмжих “Шинэ хөдөө” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

8.3.8. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, төлөвлөлт, явц, үр дүнд хяналт тавина.

---оOо---

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-
ИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 он)	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
Соёл, урлагийн салбарын хөгжлийн үзүүлэлт							
1	Зохион байгуулсан зөвт арга хэмжээ	Тоо	1	1	4-н жилд нэг удаа зохион байгуулдаг Боржигин өв соёлын наадмын тоо	2 жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар
2	1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	Тоо	550	900	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Боловсрол, соёл урлагийн газар
3	Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	Тоо	47.5	51	Хүүхдэд зориулсан уран бүтээл- 2, Түүхэн дуулалт болон орчин үеийн жүжиг- 3	Жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар
4	Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо	Хувь	3079	6000	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Боловсрол, соёл урлагийн газар
5	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Хувь	20	30	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Боловсрол, соёл урлагийн газар
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ							
Боловсролын салбарын хөгжлийн үзүүлэлт							
6	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт	Хувь	91	98	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар
7	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	Хувь	97.1	100	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар
8	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	98.1	100	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар
9	7-14 насны хүүхдийн суурь чадвар /унших, тоо бодох/	Хувь	унших-41 тоо бодох-30	унших-51 тоо бодох-40	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Боловсрол, соёл урлагийн газар
10	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	33	28	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар
11	ЕБС-ийн бүлэг дүүргэлт	Хувь	31	28	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Боловсрол, соёл урлагийн газар

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн үзүүлэлт							
12	Хүн амын дундаж наслалт	Жил	73.6	74	Төрөлтөөс тооцсон дундаж наслалтын хэмжээ	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
13	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промиль	11.7	10	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Эрүүл мэндийн газар
14	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	Промиль	0	0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Эрүүл мэндийн газар
15	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд	Хувь	99.8	100	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Эрүүл мэндийн газар
16	Артерийн даралт ихсэн өвчний эрт илрүүлэг	Хувь	100	100	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Эрүүл мэндийн газар
17	10000 хүн амд вируст гепатитын өвчлөл	Тоо	0	0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Эрүүл мэндийн газар
18	Чихрийн шижкин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт	Хувь	100	100	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Эрүүл мэндийн газар
19	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	74.6	85	Элэгний хавдар, Хөхний хорт хавдар, Умайн хүзүүний хавдар, Ходоодны хорт хавдар зэрэг 4 үзүүлэлтийн дунджаар тооцно.	Жилд хоёр удаа	Эрүүл мэндийн газар
20	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хэмжээ	Хувь	90,2	95	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Нийгмийн даатгалын хэлтэс
21	Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт	Хувь	99.6	100	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Эрүүл мэндийн газар
22	Улаан бурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГҮ/ эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралт	Хувь	99.5	100	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Эрүүл мэндийн газар
23	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт /насны ангиллаар/	Хувь	10.1	18.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Биеийн тамир, спортын газар

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт

24	Ядуурлын түвшин	Хувь	51.9	48	2018 оны суурь түвшин	2 жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
25	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	Оноо	80.0	88.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
26	Ажилгүйдлийн түвшин	Хувь	10.5	6.2	2020 оны II улирал	Улирал бүр	Статистикийн хэлтэс

27	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	Хувь	58.9	74.3	Орон сууцанд амьдардаг нийт хүн амын тоог улсын нийт хүн амын тоонд харьцуулж тооцно. 2015 оны завсрын тооллогоор гарсан дүн. 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор энэ үзүүлэлт шинэчлэгдэнэ.	5 жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
28	Дотоодын нийт бүтээгдэхүүн	мян.төг	112,903.20	129,838.70	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
29	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	мян.төг	6463.8	9049.32	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
30	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ	Хувь	17	16.5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
31	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ	Хувь	8.4	9.5	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
32	Тээвэр агуулахын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Хувь	15.8	17.3	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Статистикийн хэлтэс
33	Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувь	Хувь	3.8	15.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар
34	Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний нийт хэрэгцээнд эзлэх хувь	Хувь	3.0	10.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар
35	Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа хүнсний ногооны нийт хэрэгцээнд эзлэх хувь	Хувь	19.5	25.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар

ТАВ. ЗАСАГЛАЛ

Засаглалын үзүүлэлт

36	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудаас үзүүлж байгаа цахим үйлчилгээ	Тоо	Цахим үйлчилгээ үзүүлж буй, байгууллагын тоо -9 e-mongolia портал дээрх -54	Цахим үйлчилгээ үзүүлж буй, байгууллагын тоо -20 e-mongolia портал дээрх - 250	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар
----	--	-----	---	--	-----------------------	---------------	-----------------------------------

37	Шударга байдлын түвшний үнэлгээ	Хувь	72.0	80.0	2019 оны суурь түвшин /Авлигатай тэмцэх газар үнэлдэг/	Жилд нэг удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар
38	Шилэн дансны үнэлгээ	Хувь	99.3	99.7	2020 оны суурь түвшин /Сангийн яам үнэлдэг/	Жилд нэг удаа	Санхүүгийн хяналт, аудитын алба

ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ

Байгаль орчин, ногоон хөгжлийн үзүүлэлт

39	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	Хувь	37.0	45.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
40	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хэмжээ	Га	46	50	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
41	Шаардлага хангасан үндны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	62.3	79.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
42	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	Хувь	0.03	1	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
43	Сумдын төвийн тогтмол цуглувулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	Хувь	74.0	85.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
44	Орон нутгийн ногоон худалдан авалтын эзлэх хувь	Хувь	51.6	60.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Хууль сахиулах салбарын үзүүлэлт

45	Гэмт хэргийн илрүүлэлт	Хувь	55.9	60.0	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Цагдаагийн хэлтэс
46	Бүртгэгдсэн гэмт хэргийн бууралт	Хувь	12.5	15.0	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Цагдаагийн хэлтэс
47	Иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн түвшин	Хувь	66.6	70.0	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Цагдаагийн хэлтэс
48	“Оюутан цэрэг” сургалтад хамрагдах суралцагчид	тоо	8	70	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Цэргийн штаб

НАЙМ. БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ							
Дэд бүтэц, аялал жуулчлалын салбарын хөгжлийн үзүүлэлт							
49	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	Toо	213	1100	2019 оны суурь түвшин Өссөн дүнгээр тооцно.	Жилд хоёр удаа	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
50	Шинээр баригдах үерийн далан суваг, ус зайлзуулах шугамын урт	Kм	-	3.7	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно.	Жилд нэг удаа	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
51	Сумын төвийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжсэн сумын төвийн тоо	Toо	0	2	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
52	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн ўйлдвэрлэл технологийн паркийн тоо	Toо	-	1	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно.	Жилд хоёр удаа	Хүнс, хөдөө аж ахуйн газар
53	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	48.9	62.3	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
54	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	83.3	90.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
55	Орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замын хэмжээ	Kм	9.2	24.2	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	Аймгийн Засаг даргын Тамгын газар